

ШХАБ ДАХЬ МОНГОЛЫН ОРОЛЦОО БА ХЭТИЙН ТӨЛВИЙН ТАЛААРХ ЭРГЭЦҮҮЛЭЛ

*Д.Шүрхүү**

ШХАБ дахь Монголын оролцоо. 2011 он бол Шанхайн хамтын ажиллагааны байгууллага /ШХАБ/-ын хувьд 10 жилийн тэмдэглэлт ойн жил бөгөөд тус байгууллагыг эдүгээ даргалж буй Казахстан улс 6-р сарын 15-нд Астанад болох ШХАБ-ын гишүүн орнуудын тэргүүн нарын дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулах талаар нэлээд нухацтай бэлдэж байна. Эхний арван жилийн хугацаанд ШХАБ өөрийн амьдрах чадвар болон асар их нөөц бололцоотой гэлгээ бодитойгоор харуулаад зогсохгүй аажимдаа зөвлөх бүтцээс бүс нутгийн нэр хүнд бүхий байгууллага болж чаджээ. Хөгжлийн томоохон алхам хийсэн ч одоогийн ШХАБ-ын үйл ажиллагаа болоод цаашдын хөгжлийн чиг хандлагад шинжээчдийн зүгээс янз бүрийн үнэлэлт өгч байна. ШХАБ-ын талаархи шинжээчдийн өгч буй үнэлэлт дүгнэлт эрс тэрс ялгаатай, өөр хоорондоо зөрчилтэй ч харагдаж байна. Гэсэн хэдий ч ихэнхи шинжээчдийн үзэж буйгаар үнэн хэрэгтээ ШХАБ-ын цаашдын үйл ажиллагаа, түүний үндсэн оролцогч нарын хоорондхи цогц асуудлууд бүрэн шийдэгдээгүй, түүнчлэн Хятад, Оросын геополитикийн болон эдийн засгийн ашиг сонирхол Төв Азийн бүс нутагт таарч тохирохгүйн улмаас зогсонги байдалд орж байна гэж тэмдэглэжээ.¹

2004 оноос анхны ажиглагч орон болсон Монгол улс жил тутмын төр, засгийн тэргүүн нарын уулзалтуудад идэвхитэй оролцож ирсэн билээ. Энэ нь жилээс жилд өсч буй Төв Азийн улс төр, эдийн засгийн бүс нутгийн интеграцид оролцох талаар Монгол улсын гаргаж буй хүчин чармайлтыг илтгэх нэг нотолгоо юм. Ингэхдээ юуны түрүүнд транзит тээвэр болон эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулж байлаа. Монгол Улс гишүүн болон ажиглагч-орнуудын хоорондын харилцааг улам боловсронгуй болгох, хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэх тал дээр байнга анхаарал хандуулсаар ирсэн, цаашид хандуулах ч болно. ШХАБ-ын гишүүн-орнууд эдийн засгийн салбарт өргөн хүрээнд хамтран ажиллах гэсэн ажиглагч-орнуудын хүсэл сонирхлыг ойлгон хүлээн авч, харилцан ашигтай хамтын ажиллагааг тогтоох тал дээр тодорхой арга хэмжээ авч байгаад бид талархаж байдаг. Тухайлбал, ШХАБ-ын гишүүн-орнуудын салбарын сайд нарын бүх уулзалтад ажиглагч-орнуудыг тогтмол урьж оролцуулдаг практик хэвшин тогтож байгааг дурдууштай.

Бизнесийн зөвлөлийн ээлжит хуралдааныг нутагтаа зохион байгуулах тухай Монголын саналыг ШХАБ-ын зүгээс дэмжсэний үр дүнд 2010 оны 12-р сарын 23-ны өдөр Улаанбаатар хотноо Бизнесийн зөвлөлийн ээлжит хуралдаан амжилттай болж өнгөрөв.

Энэ арга хэмжээнд Казахстан, Хятад, ОХУ, Киргизстан, Тажикистан, Узбекистан зэрэг орнуудын Бизнесийн зөвлөлийн үндэсний хэсгийн ахлагч нар, ШХАБ-ын орнуудын улсын болон бизнесийн төлөөлөл оролцов.

* Д.Шүрхүү - ОУСХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор

Бизнесийн зөвлөлийн хуралдаанд анх удаа ажиглагч орон Монгол, Иран оролцлоо. Хурлаар ШХАБ-ын Бизнесийн зөвлөлийн шугамаар хэрэгжүүлж буй төслүүдэд ажиглагч-орнуудын оролцоог нэмэгдүүлэх асуудлыг хэлэлцсэний дотор эрчим хүч, тээвэр, ашигт малтмал болон эрүүл мэндийн салбаруудын хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудалд онцгой анхаарал хандуулав. Улаанбаатарын хуралдаан гишүүн болон ажиглагч орнуудын бизнесийн бүтцүүдийн хооронд ажил хэргийн хэлхээ холбоо тогтоох, түүнчлэн ШХАБ-ын хүрээнд өрнөж буй эдийн засгийн хамтын ажиллагаа болон Монголын эдийн засгийн эрчимтэй хөгжлийн шинэ чиг хандлагын талаар мэдээлэл солилцоход чухал түлхэц үзүүлсэн юм. Ер нь гишүүн болон ажиглагч орнуудын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих үүднээс Монгол улс 2012 оны ШХАБ-ын форумыг зохион байгуулахад бэлэн гэдгээ илэрхийлсэн билээ.

ШХАБ-ын хэтийн төлөв болон тэлэлтийн тухай. 2010 оны Ташкентын дээд хэмжээний уулзалтаар “ШХАБ-д шинэ гишүүн элсүүлэх журам”-ыг баталсантай холбоотойгоор ШХАБ-ын үйл ажиллагаа дэлхийн нийгэм-улс төрийн хүрээний анхаарлыг улам бүр татах боллоо. Узбекистаны Ерөнхийлөгч И.Каримов Ташкентын дээд хэмжээний уулзалт дээр үг хэлэхдээ “Уг журам гарсанаар эдүгээ ажиглагчийн статустай орнууд автоматаар ШХАБ-ын гишүүн болно гэсэн үг биш боловч тус баримт бичиг ШХАБ өргөжих бодит боломжийг нээж өгч байгаа юм” хэмээн мэдэгджээ.² Одоогийн байдлаар Үндэсний зохицуулагчдийн Зөвлөл ШХАБ-ын гишүүнчлэлтэй холбогдсон санамж бичгийн загвар болон хууль эрх зүй, зохион байгуулалт, санхүүгийн бусад баримт бичгүүдийг боловсруулж байна.

«Коммерсанты» сонинд ШХАБ-ын гишүүнээр элсэх хүсэлт гаргасан оронд тавих 8 зүйл шалгуур үзүүлэлтийг дурджээ. Тухайлбал, элсэх нэр дэвшигч орон нь евроазийн бүс нутагт орших, ШХАБ-ын бүх гишүүн-орнуудтай дипломат харилцаатай байх, ажиглагчийн эсвэл яриа хэлэлцээний түншийн статустай байх, ШХАБ-ын гишүүн-орнуудтай худалдаа-эдийн засгийн болон хүмүүнлэгийн идэвхитэй харилцаа тогтоосон байх, ШХАБ-д гишүүнээр элсэхээр зэхэж буй орны аюулгүйн байдлын талаар хүлээсэн олон улсын үүрэг тухайн байгууллагын хүрээнд байгуулсан олон улсын гэрээ болоод бусад баримтуудтай харшлахгүй байх, тус орон өөрөө ямар нэгэн улстай зэвсэгт мөргөлдөөний байдалд ороогүй байх, НҮБ-ын дүрмийн дагуу хүлээсэн үүргээ шударга үнэнчээр биелүүлдэг байх, НҮБ-ын ямар нэг хоригт ороогүй байх гэсэн 8 шаардлага багтжээ. Ингэхээр НҮБ-ын зүгээс тавьсан хоригт орсон Иран улс ойрын жилүүдэд ШХАБ-ын бүрэн эрхт гишүүн болох боломжгүй гэсэн үг юм.

ШХАБ-ын гишүүн болох хамгийн өндөр магадлалтай орноор ажиглагчийн статус бүхий Энэтхэг, Пакистан, Монгол 3 орон тооцогдож байна. Энэтхэгийн засгийн газрын эх сурвалжийг иш татан ИТАР-ТАСС агентлагаас цацсан мэдээнээс үзэхэд Энэтхэг улс “ажиглагчийн статустайгаар тус байгууллагад гүйцэтгэх өөрийн үүргийг нэмэгдүүлэхэд бэлэн байгаа бөгөөд журам батлагдсаны дараа элсэх асуудлыг нухацтай судлана” гэсэн байр суурьтай байгаа ажээ.³ Зарим судлаачид, ялангуяа

Оросын шинжээчид, хамгийн магадлал өндөртэй улс бол Энэтхэг гэж үзэж байна. Алс Дорнодын институтын орлогч захирал С.Лузянин “ШХАБ бүс нутгийн томоохон улс болох Энэтхэгээр эгнээгээ тэлбэл бүс нутаг болон дэлхийн хэмжээний хамгийн нөлөө бүхий бүтцийн нэгд тооцогдон түүний нэр хүнд улам өсөх болно. Үүнээс гадна Энэтхэгийн гишүүнчлэл нь ШХАБ-ыг дэлхийн хэмжээний аюулгүй байдал, санхүү-эдийн засгийн тогтвортой байдал, Ази-Номхон далай, Евроази болон Өмнөд Азийн бүс нутгийн хөгжил, шинэчлэлийн гол баталгаа болгон хувиргана” гэж үзэж байна.

Гэвч Энэтхэг, Пакистаны хооронд оршиж буй газар нутгийн ноцтой маргаан, геополитикийн ашиг сонирхлын зөрөлдөөн нь тэдний ШХАБ-д элсэх асуудлыг нэлээд бүдгэрүүлж болзошгүй юм. Мөн түүнчлэн нэлээд зөрчил бүхий Азийн энэ хоёр улсыг элсүүлсэн тохиолдолд ШХАБ-ын интеграцчилалд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай тул одоохондоо тус орнуудыг элсүүлэх гэж нэг их яарахгүй бололтой. Зарим мэрэгжилтнүүдийн зүгээс нэр дэвшигчдэд тавих шаардлагууд дотор цөмийн хэлэлцээрийн талаархи заалт оруулж өгөх нь зүйтэй гэсэн санал дуулдах болов.⁴ Хэрэв журамд үнэхээр ийм заалт оруулж ирвэл цөмийн зэвсгээс ангид байх статустаа байнга баталгаа хайдаг Монголын зүгээс ШХАБ-ыг сонирхох нэмэлт хүчин зүйл болох талтай.

Судлаачдын ихэнхи нь Монгол улсыг ШХАБ-ын байнгын гишүүнээр элсэх хамгийн их боломжтой орны нэгд зүй ёсоор тооцдог. Гэхдээ гадаад болон дотоод хэд хэдэн хүчин зүйлийн улмаас Монгол Улс ШХАБ-д ойрын үед элсэн орох боломж бүрдээгүй хэмээн миний бие үзэж байна. Гадаад хүчин зүйлийн нэг нь Төв Азид зөрчил мөргөлдөөн гарах, тогтворгүй байдал үүсэх потенциал жилээс жилд нэмэгдэх хандлагатай болсон явдал юм. Үүний нотолгоо бол бүс нутгийн зарим орнуудад үе үе гарах болсон дотоодын зөрчил мөргөлдөөн юм(2008-2009 онд Хятадын баруун мужуудад, 2010 оны зуны Киргизстанд болсон үндэстэн хоорондын мөргөлдөөн гэх мэт). Түүнээс гадна Афганы дайн, газар нутгийн болон усны маргааны улмаас бүс нутгийн улс орнуудын хооронд ч үл итгэлцэл, зөрчил мөргөлдөөний байдал нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь ШХАБ-ын орон зай дахь геополитикийн хүчний дахин хуваарилалт ил далд хэлбэрээр явагдаж, дэлхийн улс төрийн бодлогын томоохон тоглогчдын дунд Төв Ази дахь нөлөөний хүрээгээ тэлэхийн тэмцэл хурцдаж байгаатай холбоотой.

Анхаарвал зохих буй өөр нэг зүйл бол ШХАБ дахь Орос, Хятадын хоорондын ашиг сонирхлын зөрчил нэмэгдэж буй явдал юм. Иймэрхүү зөрчил онолын хувьд боломжтой зүйл бөгөөд үйл явц ийм маягаар гүнзгийрэн лавширсан тохиолдолд Монголын хувьд Орос, Хятадын аль нэгийг сонгох зайлшгүй шаардлага гарах учраас энэ нь бидний хувьд маш тааламжгүй зүйл билээ. Монгол улс хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцахыг эрмэлзэж буй бөгөөд үүний ачаар Бээжин Москва хоёр Монголын эрдэс баялгийн төлөө шударгаар өрсөлдөх, элдэв зөрчлөөс зайлсхийх боломж гарч ирэх юм.

Монгол улс ШХАБ-д элсэх эсэхийг тодорхойлох дотоодын хүчин зүйлсийн дотроос хамгийн чухал нь шийдвэр гаргах түвшин дэх улс төрийн

зөвшилцөлд хүрэх явдал юм. Өөрөөр хэлбэл Монгол Улсын гадаад бодлого, аюулгүй байдалтай холбоо бүхий томоохон шийдвэрийг заавал хууль тогтоох дээд байгууллага буюу УИХ-аар хэлэлцүүлж гаргах хууль журамтай тул Монгол Улс ШХАБ-д элсэхийн тулд эхлээд УИХ-аас дэмжлэг авсан байх шаардлагатай. Одоогийн байдлаар улс төрчдийн дунд ч, судлаач-эрдэмтдийн дунд ч энэ асуудал нээлттэй хэвээр байгаа. Өнөөгийн нөхцөлд Монгол Улс ШХАБ-д байнгын гишүүнээр элсэх шаардлагагүй, цаг нь болоогүй гэсэн үзэл бодол Монголын олон нийтийн дунд давамгайлж байна.

Зарим судлаачид Монгол улс эдийн засаг, санхүү, боловсон хүчний нөөц хангалтгүй, Төв Азийн бүс нутагтай холбогдох дэд бүтцийн сүлжээ байхгүй, түүнчлэн хоёр Орос, Хятадаас бусад ШХАБ-ын гишүүн-орнуудтай худалдаа-эдийн засаг болон хүмүүнлэгийн харилцаа бараг байхгүй зэрэг бодит шалтгааны улмаас ШХАБ-ын байнгын гишүүн болоход одоогоор бэлэн биш гэж үздэг.

Гэхдээ ШХАБ-д элсэхээс түдгэлзэнэ гэдэг бол Монгол улс бүс нутгийн интеграцийн үйл явцаас сугран үлдэнэ гэсэн үг бас биш юм. Газар зүйн алслагдмал байршил, худалдаа-эдийн засгаа олон чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх гэсэн хүсэл эрмэлзлэл зэрэг олон хүчин зүйлс Монгол улсыг өөрийн эрхгүй бүс нутгийн эдийн засгийн интеграцчлал руу хөтлөх болно. Монгол орон баруун тийшээ чиглэсэн бүс нутгийн интеграцчлалд хэзээ, хэрхэн нэгдэн орох нь зарчмын өөр асуудал билээ. Хэрэв тааламжтай нөхцөл бүрэлдэж, тохиромжтой цаг үе ирвэл Монгол Улс ШХАБ-д дуртайя элсэн орох нь дамжиггүй. Тийм ч учраас Монгол Улс ШХАБ-ын бүхий л үйл ажиллагаа, хөгжил хандлагыг машид анхааралтай ажиглан, бололцооныхоо хэрээр хамтран ажиллахыг ямагт эрмэлзсээр ирсэн билээ.

Далайд гаршгүй эх газрын орны хувьд Монгол Улс ШХАБ-ын гишүүн орнуудын хэрэгжүүлж буй тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх томоохон төслүүдэд оролцохыг ихээхэн сонирхож байдаг. Жишээ нь, Хятад улс дотооддоо өндөр хурдны төмөр замын шинэ сүлжээ барьж, цаашдаа Хятадын хилийн чанад руу тэлэх, Ази-Европыг холбох тив дамнасан асар том төслүүдийг хэрэгжүүлэхээр бэлтгэж байна. Хятад улсад Төв Азийн Казахстан, Узбекистан, Турменистан зэрэг улсуудыг дайруулан Герман хүрэх өндөр хурдны төмөр замын сүлжээг байгуулах туршилт судалгааны ажил хэдийнээ эхэлсэн тухай мэдээ ч зарим хэвлэлд гарч байна.⁵

ОХУ ч Төв Ази дахь Хятадын идэвхитэй үйл ажиллагааг гар хүмхин харж суухыг хүсэхгүй байна. Өнгөрсөн оны сүүлчээр Душанбед болсон ШХАБ-ын гишүүн орнуудын засгийн газрын тэргүүн нарын Зөвлөлийн хуралдаан дээр ОХУ-ын Засгийн газрын тэргүүн В.Путин ирэх арван жилд ШХАБ-ын гишүүн орнуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөр - "замын зургийг" боловсруулах талаар сонирхолтой шинэлэг санаа дэвшүүлсэн. Бидэнд хамтдаа хөгжих бүх талын боломж бололцоо байна, түүний дотор ШХАБ-ын орон зайд тээврийн болон транзитийн асар их нөөц бололцоо байна. Өөрөөр хэлбэл "Ази-Европ" болон "Умард-Өмнөд" гэсэн тив дамнасан хонгилууд барих тухай санал дэвшүүлж байгаагаа Оросын ерөнхий сайд тайлбарласан ажээ. Ноён Путины энэхүү санал

дотор бидний анхаарлыг ихэд татаж буй нэг зүйл бол энэхүү санал санаачилга нь зөвхөн гишүүн орнуудаар хязгаарлагдахгүй бөгөөд ажиглагч, яриа хэлэлцээний түнш орнууд болон сонирхогч бусад орнуудыг уг төсөлд идэвхитэй оролцохыг уриалсан явдал байлаа.

Нөөцөөрөө дэлхийд дээгүүрт орох Оюутолгойн алт-зэс, Тавантолгойн нүүрсний томоохон ордууд ашиглалтад орсоноор Монголын эдийн засгийн хөгжил ойрын ирээдүйд эрс түргэсэх төлөв ажиглагдаж эхэллээ. Засгийн газрын тооцоогоор дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 2013 он гэхэд 20.8% буюу хамгийн дээд түвшинд хүрч, цаашид ойролцоогоор жилийн 13-14 хувь дээр тогтоно гэж таамаглаж байна.⁶ Монгол улс сүүлийн жилүүдэд ашигт малтмалын томоохон орд газруудаа эдийн засгийн эргэлтэд оруулах үйл явцаа түргэтгэхийг эрмэлзэж байгаа билээ. Ялангуяа нүүрсний салбарт ихээхэн ач холбогдол өгч байна. Зөвхөн 2010 онд Монгол улс 25 сая тонн нүүрс олборлож, 18 сая тонныг нь Хятад руу экспортлосон бөгөөд нүүрсний экспортын нийт үнийн дүн 877.6 сая ам.долларт хүрсэнээр нүүрс нь олон жилийн турш манай экспортын гол бүтээгдэхүүн болж байсан зэсийн баяжмалыг хоёрдугаар байр луу шахсан юм.⁷

Эдгээр уул уурхайн томоохон төслүүдээс гадна “Төмөр замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлого”, дунд хугацааны “Шинэ бүтээн байгуулалт” зэрэг төслүүдийг Монгол улс хэрэгжүүлж эхэлж байгаа нь ШХАБ-ын гишүүн болон ажиглагч орнуудтай уул уурхай, эрчим хүч, дэд бүтцийн салбаруудад улам өргөн хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлэх шинэ боломж, бололцоо нээж өгч байна.

Үүнээс гадна ШХАБ-ын гишүүн орнуудын анхаарал сонирхлыг ихээхэн татах өөр нэг стратегийн чухал түүхий эд Монгол улсад байна. Энэ бол уран юм. Өнгөрсөн онд Москва хотын Президент зочид буудалд болж өнгөрсөн “ШХАБ-ын орон зай дахь цөмийн хамтын ажиллагаа” бага хурал ШХАБ-ын хүрээнд эрчим хүчний яриа хэлэлцээрийн механизм ажиллаж эхэлсэнийг нотолсон юм. ШХАБ-ын “Эрчим хүчний клуб” эхний арга хэмжээгээ “цөмийн эрчим хүч”, бүр тодруулбал “уран” тойрсон хэлэлцүүлгээр эхэлсэний учир шалтгааныг олж ядах зүйл биш билээ. Хурлын үеэр шинжээчид ШХАБ-ын орон зайд ураны салбарт хамтын ажиллагаа хөгжүүлэх боломжтой 3 хувилбар байгааг дурдсаны дотор дэлхийн ураны зах зээл дээр алс хэтдээ шинэ тоглогч болох ирээдүйтэй Монголыг цохон тэмдэглэж байв.⁸

Тэгээд ч ШХАБ-ын орнууд худалдаа, эдийн засаг, ялангуяа эрчим хүчний чиглэлээр харилцан нөхсөн хамтын ажиллагааг хөгжүүлэх асар их потенциалтай юм. ШХАБ-ын гишүүн орнуудын нэг хэсэг ОХУ, Казахстан нь эрчим хүчний түүхий эдийн томоохон экспортлогч байхад, Хятад зэрэг нөгөө хэсэг нь том импортлогч юм. Тажикистаны шинжээч Ш.Бобоевын үзэж буйгаар одоо баригдаж байгаа замууд Төв Азийн газар зүйн хувьд алслагдсан улс орнуудад шинэ орон зай нээж өгөхөд онцгой үүрэг гүйцэтгэж байна. Бий болж байгаа эдгээр сүлжээнүүд энэ орон зайг дахин амилуулж ачаа тээвэр хийх тааламжтай бөгөөд аюулгүй нөхцөлийг бий болгох ажээ.⁹ Геоэдийн засгийн үүднээс Монгол улс өөрийгөө Зүүн Хойд Азийн улс гэж

тооцон, энэ бүс нутаг дахь олон улсын үйл явцад орох явдлыг бодлогын тэргүүлэх чиглэлдээ оруулдаг юм. Хэрэв Монгол улс ШХАБ-д элссэн тохиолдолд Зүүн Хойд Азийг Төв Азитай, ШХАБ-ын гишүүн орнууд тус бүс нутагт хамтран ажиллахад Монгол Улс холбогч, зуучлагчийн үүргийг давхар гүйцэтгэх таатай нөхцөл бүрдэх юм.

Энэ үүднээс авч үзвэл Монгол улс ШХАБ-ын бүх гишүүн орнуудтай гурав эсвэл дөрвөн талт харилцаа хөгжүүлэх хэрэгтэй бөгөөд шаардлагатай байгаа юм. Ийнхүү Монгол улс өөрийн боломж бололцоондоо тулгуурлан ШХАБ-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох бодлогыг баримталсаар ирсан, цаашид баримтлах болно.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Перспективы развития Шанхайской Организации Сотрудничества <http://www.easttime.ru/reganalitic/1/240.html>
2. Положение о вступлении в ШОС не означает ее автоматического расширения, 11/06/2010 - РИА Новости.
3. Иран водят за ШОС// Россия и Китай придумали, как отказать Тегерану в присоединении к “шанхайской шестерке”. Газета «Коммерсантъ» №103 (4403) от 11.06.2010
4. Перспективы развития Шанхайской Организации Сотрудничества <http://www.easttime.ru/reganalitic/1/240.html>
5. Китай соединит железной дорогой страны Центральной Азии с Европой. 04.02.2011 <http://www.infoshos.ru/>
6. <http://www.ndic.gov.mn/>
7. <http://www.mmre.energy.mn/statistic/>
8. Деловой Совет ШОС открыл двери “Энергетического клуба”, 2010-04-16
9. Ш.Бобоев. Расширение ШОС. Перспективы стран - претендентов на членство в Шанхайской Организации сотрудничества, 01.12.2010